**ЧУЛУУНХОРООТ СУМЫН СУРГУУЛЬ**

# *ХҮНСНИЙ МАТЕРИАЛ* НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Гэрээний дугаар: ***ДОАЧХСЕБС/202001012***

2020.03.09

## **Нэг.** ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2020-03-09
Тендер шалгаруулалтын нэр: Дотуур байрны хүүхдийн хоол
Тендер шалгаруулалтын дугаар: ДОАЧХСЕБС/202001012

Дорнод аймгийн Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургууль нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Дотуур байрны хүүхдийн хоол -г гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.
Үнийн санал ирүүлэх ажлын зураг , техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.
Үнийн саналыг 2020 оны 03 -р сарын 26 -ны өдрийн 10 цаг 00 минут-с өмнө Монгол, Дорнод, Чулуунхороот сум (Эрээнцав), 1-р баг , Дэлгэр, Хичээлийн байр, 3 хаягаар ирүүлнэ.
Цахим тендер бол цахим системээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 03 -р сарын 26 -ны өдрийн 10 цаг 10 минут -т нээнэ.
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол, Дорнод, Чулуунхороот сум (Эрээнцав), 1-р баг , Дэлгэр, Хичээлийн байр, 3
Утас: 89995190 , Факс:
Имэйл хаяг: do.chuluunkhoroots@gmail.com
Веб хаяг:

## Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

| | | |
|---|---|---|
| **1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа** | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| **2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт** | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| **3. Тендерийн иж бүрдэл** | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| **4. Тогтмол үнэ** | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| **5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд** | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| **6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш ***45*** хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| **7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ***ТШӨХ-д*** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл |

шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

| **ТОӨЗ-ны холбогдох заалт** | **А. Ерөнхий зүйл** |
|---|---|
| **ТОӨЗ 1.1** | Захиалагч нь: ***Дорнод аймгийн Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургууль*** |
| **ТОӨЗ 1.1** | Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар:<br>***Дотуур байрны хүүхдийн хоол*** ДОАЧХСХЦ/202001012 |
| **ТОӨЗ 1.2** | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:<br>***Багц-1: Бэлэн бүтээгдэхүүн -11721000***<br>***Багц-2: Мах, махан бүтээгдэхүүн-23220600***<br>***Багц-3: Сүү, сүүн бүтээгдэхүүн-840000***<br>***Багц-4: Хүнсний ногоо-4694000***<br>***Багц-5: Гурил, гурилан бүтээгдхүүн-2937000***<br><br>Оролцогч тендерийн маягтад сонирхож буй багц тус бүрийн үнийн санал болон нийт үнийн саналыг тусгана. Багц тус бүрийн үнийн санал тусгаагүй тендерээс татгалзана. |
| **ТОӨЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***Улсын төсвийн хөрөнгө***<br>Төсөвт өртөг: ***43412600*** |
| | **Б. Тендерийн баримт бичиг** |

| | |
|---|---|
| **ТОӨЗ 8.1** | Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:<br>***Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургууль***<br>***Утас: 89900866*** |
| **ТОӨЗ 8.1** | Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын **5 хоногоос багагүй байна.** |
| | **В. Тендер бэлтгэх** |
| **ТОӨЗ 11.1** | Тендерийг ***Монгол хэл*** дээр бэлтгэнэ. |
| **ТОӨЗ 12.1 (ё)** | Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд:<br>– ***Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/***<br>– ***Татварын албаны тодорхойлолт,***<br>– ***Банк, санхүүгийн байгууллагаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй эсэх тодорхойлолт***<br>– ***Харилцагч банкны харилцах дансны хуулга /сүүлийн зургаан сараар/***<br>– ***Шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт,***<br>– ***Үйлдвэрлэгчийн гаргасан техникийн тодорхойлолт болон фото зураг.***<br>– ***Бараа нийлүүлэх хуваарь /Маягтын дагуу/***<br>– ***Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл***<br>– ***Техникийн тодорхойлолтын ерөнхий шаардлагын хэсэгт шаардсан бусад материалууд*** |
| **ТОӨЗ 14.1** | Хувилбарт тендер ирүүлэхийг***"зөвшөөрөхгүй"*** |
| **ТОӨЗ 15.5** | Олон улсын худалдааны Incoterms /Инкотермс -ийн хувилбар: ***Шаардлагагүй*** |
| **ТОӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)** | Бараа хүргэгдэх газар: ***Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургууль*** |
| **ТОӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)** | Бараа хүргэгдэх эцсийн цэг : ***Чулуунхороот Ерөнхий боловсролын сургуульд*** |
| **ТОӨЗ 15.9 (б) (1)** | Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТОӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан CIP үнээс үнэ байна. Энэ үнэнд НӨАТ, Гаалийн татвар багтсан байна. |
| **ТОӨЗ 15.10** | Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн |

| | |
|---|---|
| | явцад ***тохируулахгүй тогтмол байна.*** |
| **ТӨЗ 16.1** | Тендерийн валют ***төгрөг байна.*** |
| **ТӨЗ 18.1 (а)** | Барааг, хаанаас, хэрхэн нийлүүлэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт, материалыг тендерийн хамт ирүүлнэ. |
| **ТӨЗ 18.1 (б)** | Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:***2018, 2019 оны жилийн эцсийн тайлан*** |
| **ТӨЗ 18.1 (г)** | Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: |
| **ТӨЗ 18.1 (д)** | Бараag нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: ***Шаардлагагүй*** |
| **ТӨЗ 18.2 (а)** | Борлуулалтын хэмжээ: ***50 хувь*** |
| **ТӨЗ 18.2 (б)** | Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: ***шаардлагагүй*** |
| **ТӨЗ 18.2 (в)** | Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: ***Шаардлагагүй*** |
| **ТӨЗ 18.2 (г)** | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: ***Шаардлагагүй*** |
| **ТӨЗ 18.2 (д)** | Ашигтай ажилласан байх жилийн тоо: ***Шаардлагагүй*** |
| **ТӨЗ 18.4(д)** | Дотоодын давуу эрхийн зөрүү: ***Тооцохгүй.*** |
| **ТӨЗ 19.1.(б)** | Баталгаат хугацаа: 1 жил |
| **ТӨЗ 20.1** | Тендер нээснээс хойш ***30*** хоногийн туршид хүчинтэй байна. |
| **ТӨЗ 21.1** | Тендерийн баталгааны үнийн дүн: |
| **ТӨЗ 22.1** | Тендерийн эх хувиас гадна хуулбар хувь ирүүлэх шаардлагагүй. |
| | **Г. Тендер ирүүлэх** |
| **ТӨЗ 23.3 (б)** | Тендер хүлээн авах захиалагчийн хаяг<br>Тендер хүлээн авах этгээд: ***Чулуунхороот сум Ерөнхий боловсролын сургууль***<br>Аймаг, хот: ***Дорнод аймаг Чулуунхороот сум***<br>Байгууллагын хаяг: ***Чулуунхороот*** **сумын** ***Ерөнхий боловсролын сургууль*** |

| | |
|---|---|
| | Давхар болон өрөөний дугаар: 1 давхарт №1<br>Утас:89996670 |
| **ТОӨЗ 23.3 (в)** | Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: ДОАЧХСХЦ/202001012 дугаартай ***Дотуур байрны хүүхдийн хоол*** тендер<br>/Оролцогчийн хаяг, холбоо барих утас, цахим шуудан/ |
| **ТОӨЗ 24.1** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо:***2020 оны 03 дугаар сарын 26-ны өдөр***<br>Цаг: ***10 цаг 00 минут*** |
| | |
| | **Д. Тендерийг нээх, үнэлэх** |
| **ТОӨЗ 28.1** | Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:<br>Аймаг, хот: ***Дорнод аймаг Чулуунхороот сум***<br>Байшин, гудамжны нэр: ***Чулуунхороот сум Ерөнхий боловсролын сургууль***<br><br>Давхар болон өрөөний дугаар: ***1 давхарт №1***<br>Улс: ***Монгол***<br>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:<br>Огноо: ***2020 оны 03 дугаар сарын 26-ны өдөр***<br>Цаг: ***10 цаг 10 минут*** |